

5 үе шат

Хандлага өөрчлөх

1-Р ҮЕ ШАТ: МУНХАГЛАЛ

Сул дорой байдал, хөгжлийн бэрхшээл нь Бурханд хамаагүй болохын дохио эсвэл тухайн нөхцөл байдлыг засаж чадахгүйн дохио юм. Үнэндээ, энэ нь гэм нүглийн эсвэл итгэл үнэмшилгүй байсны үр дагавар ч байж мэднэ. Бурхан хөгжлийн бэрхшээлтэй хүний амьдралд оролцдоггүй яагаад гэвэл Тэр тэгтлээ гэмтсэн хүмүүсийг ашиглаж чадахгүй. Би хөгжлийн бэрхшээлтэй хүн танихгүй, хөгжлийн бэрхшээлийн талаар юу ч мэдэхгүй. Надад тэдэнтэй танилцах эсвэл тэдний амьдралын тухай таньж мэдэх сонирхол алга.

2-Р ҮЕ ШАТ: ХАРУУСАЛ

Би хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг өрөвдөж байна. Үнэхээр, харамсалтай юм. Бурхан намайг ивээсэн бөгөөд би бусдад туслах боломжтой. Хүүхдүүд минь хөгжлийн бэрхшээлгүйд талархаж байна. Сул дорой болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст зовлон бэрхшээлээ давахад нь над мэт хүмүүс туслах, амьдралд нь утга учир өгөх хэрэгцээ байх нь илэрхий. Тэдний амьдралд утга учир, зорилго би үнэндээ олж харж чадахгүй байна.

3-Р ҮЕ ШАТ: ЭНЭРЭЛ

Надтай адилхан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг Бурхан өөрийн төрхөөр бүтээсэн. Энэ үзэл суртахуун дангаараа ч тэдний үнэ цэнийг илэрхийлнэ. Хэн нэгэн цаг гарган тэдэнд Бурханы хайрыг харуулаасай, би ийм санаачилгыг таатай дэмжих болно. Ер нь, бид ийм хүмүүст туслах арга зам олох хэрэгтэй гэж би бодож байна. Магадгүй бид сүмийн тусгай боловсролын анги эсвэл эцэг эхэд зориулсан түр амсхийх хөтөлбөр эхлүүлж болох юм.

4-Р ҮЕ ШАТ: НӨХӨРЛӨЛ

Би хөгжлийн бэрхшээлтэй нэг найзтай болоод түүнтэй хамт цаг өнгөрөөсөн. Энэ хүн Бурханы хувьд, бас миний хувьд, үнэ цэнтэй бөгөөд түүнийг таньж мэдсэнээр миний амьдралд эерэг өөрчлөлт ирж буйг би мэднэ, мөн би түүнд тусалдгийн адилаар тэр ч надад ивээл болдог. Ер нь, би одоогоос хөгжлийн бэрхшээлтэй хүмүүстэй харилцаж эхлэхийг хүсэж байна. Бурхан төрөл бүрийн хүмүүсийг манай сүмд, хамт олны маань дунд авчирдаг, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс ч бас бий бөгөөд бид нөхөрлөлөөр өсөж дэвжиж байдаг.

5-Р ҮЕ ШАТ: ХАМТРАН ЗҮТГЭГЧ

Хэрэв Бурхан бидний хүн нэг бүрийг өөрийг нь бүхий л хүч чадлаараа магтаж, түүнд үйлчлэхээр дуудсан юм бол Тэр бидний хөгжлийн бэрхшээлтэй Христийн ах эгч дүүсийг ч мөн адил зүйлд дуудсан. Миний бодлоор үйлчлэл зөвхөн хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс руу хандсан байх биш харин тэдэнтэй хамт, зэрэгцэн явагдах ёстой. Бид харилцан нэгэндээ урам зориг өгч, хөгжлийн бэрхшээлтэй, бэрхшээлгүй харилцан нэгнээ хүчирхэгжүүлж, Бурханы бидний амьдралд өгсөн дуудлагад хариу өгөхөөр бүхий л сайн үйлд хамтдаа зүтгэнэ. Бид бүгд өгч чадна, бид бүгд авч чадна.

МЭДЛЭГ МЭДЭЭЛЭЛТҮГЭЭХ

БОЛОМЖООР ХАНГАХ

НЭГТГЭХ

ОРОЛЦУУЛАХ



VISIT THE WHEATON CENTER FOR FAITH AND DISABILITY FOR MORE INFORMATION AND RESOURCES.



Wheaton Center for FAITH AND DISABILITY

"5 STAGES: CHANGING ATTITUDES" IS COPYRIGHT © 2009, DAN VANDER PLAATS, WITH THANKS TO ELIM CHRISTIAN SERVICES, DISABILITY CONCERNS CRC AND RCA, ENGAGING DISABILITY, JONI AND FRIENDS, AND WHEATON COLLEGE